



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 1/01

Мөрөн сум

2026 оны цэргийн бүртгэл
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дугаар зүйлийн 59.1.1 дэх заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Аймгийн Засаг даргын 2025 оны А/690 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Цэргийн бүртгэлийг зохион байгуулах сумын ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн дарга:
Гишүүдэд:

Засаг даргын Тамгын газрын дарга
Улсын бүртгэгч
Төрийн сангийн мэргэжилтэн
Зөөлөн багийн Засаг дарга
Өлзийт багийн Засаг дарга
Бүрээт багийн Засаг дарга
Цагаан толгой багийн Засаг дарга
Чандган багийн Засаг дарга

2.2026 оны Цэргийн бүртгэлийг сумын хэмжээнд 2026 оны 01 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийг дуустал хугацаанд зохион байгуулсугай.

3.Цэргийн бүртгэлд хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулж, биечлэн болон цахимаар бүртгэж, 2025 оны жилийн эцсийн хүн амын тоотой /Маягт-ХА-3/ тулган, мэдээ судалгааг маягтын дагуу үнэн зөв гаргаж 2026 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Аймгийн цэргийн штабт хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга (Н.Намжилноров)-т даалгасугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР